Энхийг дэмжих ажиллагаанд бэлтгэгдэж буй цэргийн албан хаагчдын сэтгэлзүйн хэвшинж, сэтгэцийн зарим үзүүлэлтийг судалсан дүн

Н.Өлзийхутаг[1], З.Хишигсүрэн[1]

[1]АШУҮИС, АУС, СЭМ-ийн Тэнхим
Цахим шуудан: ulziikhutag.md@gmail.com, Утас: 99043344

Түлхүүр үг:

Өмнөд Судан
Сэтгэл түгшилт
Архины хамаарал
Цэрэг дайчид

Товч утга:

Үндэслэл: НҮБ-ын ивээл дор явуулж буй энхийг дэмжих ажиллагаа идэвхижсэн сүүлийн 30-аад жилийн түүхээс үзэхэд байлдааны ажиллагаа нь энхийг дэмжих үйл ажиллагаанд оролцогчдын сэтгэлзүйн дарамт зовуурийг ихэсгэн, сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг үүсгэн, амьдралын чанарыг бууруулдаг болох нь харагдаж байна. Иймд бид НҮБ-ийн Энхийг дэмжих ажиллагаанд Монгол улсаас оролцож буй энхийг дэмжигчдийн сэтгэцийн эрүүл мэндэд дайн, тулаантай нутаг орны байдал хэрхэн нөлөөлж буйг судлан тогтоох шаардлагатай байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдын сэтгэцийн эрүүл мэндийн зарим үзүүлэлтийг сэтгэлзүйн хэв шинжтэй нь уялдуулан судлаж тусламжийн хэрэгцээг судлан тогтоох. **Арга, аргачлал**: Судалгааг Өмнөд Судан улсад явагдах энхийг дэмжих ажиллагаанд бэлтгэгдэж буй цэргийн албан хаагчдын дунд дескриптив судалгааны агшингийн загвараар хийж гүйцэтгэв. **Үр дүн.** Судалгаанд 20-47 насны нийт 372 цэргийн албан хаагч таниулсан зөвшөөрлийн хуудастай танилцан, сайн дураар хамрагдсан бөгөөд тэдний 20-34 насныхан 81.1%, байсан бөгөөд хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэйчүүд 90% байв (p≤0.001). Судалгаанд нийт оролцогчийн 45.1% нь тусгай дунд, 37% нь дээд боловсролтой, 72.3% нь гэр бүлтэй, 72.9% нь 0-3 насны хүүхэдтэй байв (p≤0.001). Судалгаанд хамрагдагсадын 99% нь өөрийн хүсэлтээр энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа ба 47.3% (p≤0.001) нь урьд нь энхийг дэмжих ажиллагаанд оролцож байсан туршлагатай байлаа. Энхийг дэмжих ажиллагааны бэлтгэл нь цэргийн албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэхээс (p≤0.001) гадна сэтгэлзүйн бэлтгэл (p≤0.001), стрессийг даван туулах чадвар (p=0.002), багаар хамтран ажиллах чадвар (p≤0.001)-ыг хөгжүүлэх боломжийг олгосон хэмээн 60-78% нь хариулсан байв. Хувь хүний сэтгэлзүйн хэвшинжийг Айзенкийн сорилоор тодорхойлоход, 21.5% холерик, 35.2% сангвиник, 24.2% флегматик, 9.1% нь меланхолик хэв шинжтэй байлаа. Неврозын илрэл нь меланхолик хэв шинжийн оролцогчдод бусад хэв шинжийн оролцогчдоос статистик ач холбогдол бүхий (p≤0.001) ялгаатай тодорхойлогдсон болно. Архины хэрэглээг үнэлэхэд, нийт оролцогчийн 89.5% (n=333) нь бага хэрэглээтэй, 9.9% (n=37) нь хэтрүүлэн хэрэглэгч байсан бол нас ахих тусам архины хэрэглээний түвшин ихтэй буюу хэтрүүлэн хэрэглэгч, хортой үр дагавар өгөхүйц хэрэглээтэй оролцогчийн тоо нэмэгдэж, 35-аас дээш насныхны дунд архины хэрэглээ статистик ач холбогдол бүхий (p=0.002) ялгаатай байлаа. **Дүгнэлт**: Энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор бэлтгэгдэж буй цэргийн албан хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийн зарим үзүүлэлт нь хувь хүний сэтгэлзүйн хэвшинжээс хамааран ялгаатай (p≤0.001) тодорхойлогдож байсан ба архины хэрэглээ 35-аас дээш насныханд илүү байгаа нь цаашид цэргийн алба хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, стресс тайлах энгийн аргад суралцах, сэтгэцийн эмгэгт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг авах шаардлагатайг харуулж байна.

Үндэслэл: Дайн байлдааны талбарт биечлэн үүрэг гүйцэтгэж, энхийг дэмжих ажиллагаанд оролцох нь цэрэг дайчид, алба хаагчид сүйрүүлэх түвшний хүчтэй стресст шууд нэрвэгдэх нөхцөлийг үүсгэдэг. НҮБ-ын ивээл дор явуулж буй энхийг дэмжих ажиллагаа идэвхижсэн сүүлийн 30-аад жилийн түүхээс үзэхэд байлдааны ажиллагаа нь цэргийн албан хаагчдад сэтгэлзүйн дарамт учруулж, эрүүл мэнд, амьдралын

чанарыг бууруулснаар зан төрхийн өөрчлөлт үүсэхэд нөлөөлж, энхийг дэмжих ажиллагаа явагдаж буй тухайн нутаг орны энгийн иргэдэд хүчирхийлэл үйлдэх тохиолдол цөөнгүй гардаг болохыг судлаачид тэмдэглэсэн байна.[2]

Ирак, Афганистаны байлдааны ажиллагаанаас үүдэлтэйгээр энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдод сэтгэцийн эрүүл мэндийн олон асуудал үүсдэг болохыг судлаач Песли Д (2017) нар тогтоожээ.[1] Тухайлбал, 2007 онд хийсэн судалгааны дүнгээс үзвэл, Канад улсаас энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдын 35.9%-д нь сэтгэлзүйн гэмтэл үүсэх эрсдэлтэй, 2.22% нь сэтгэл түгших эмгэг, 2.47% нь сэтгэлзүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг, 6.9% нь сэтгэл гутрах эмгэг, 4.8% нь архины хараат байдалтай, 34.2% нь согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэдэг, 3.8% нь амиа хорлох бодолтой хэмээн тодорхойлогджээ. Түүнчлэн АНУ-ын батлан хамгаалах салбарт 2000-2011 онд ажиллагсдын 49% нь сэтгэцийн ямар нэгэн эмгэгээр өвчилсөн ба дасан зохицохуйн эмгэг (26%), сэтгэл гутрах (17%), сэтгэл түгших (10%) эмгэгээр оношлогдох нь эрс нэмэгдэж, тэдний 23.4 хувьд нь сэтгэлзүйн тусламж үйлчилгээ нэн шаардлагатай байгааг бүтээлдээ дурьдсан байна.[4]

2020 онд 1978-1998 оны хооронд Ливанд энхийг дэмжих үйл ажиллагаанд оролцсон Норвегийн 10605 энхийг дэмжигчдийн дунд судалгаа хийж үзэхэд үүрэг гүйцэтгэсэнээс хойш 18-38 жилийн дараа ч гэсэн сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай буюу 0.1% нь мансууруулах бодисын хэрэглээтэй, 3.4% нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг, 4% нь сэтгэл гутралтай, 6.2% нь сэтгэлийн гэмтлийн дараах стрессийн эмгэгтэй, 9.3% нь нойрны хямралтай байсан байна.[5]

Монгол Улс 2003 оноос эхлэн НҮБ-ын энхийг дэмжих үйл ажиллагаанд цэрэг, дайчдаа илгээх болсон бөгөөд Ази, Африкийн хэд хэдэн оронд болж буй байлдааны ажиллагаанд энхийг дэмжих үүрэгтэйгээр оролцоор байгаа билээ. Энэ ажиллагаанд оролцсон цэрэг дайчдын сэтгэл зүйн бэлтгэлийн талаарх судалгаа хэд хэдэн удаа хийгдэж байсан боловч цэргийн алба хаагчдын эрүүл мэнд, ялангуяа сэтгэцийн эрүүл мэндэд дайн, байлдаан, тулааны үйл явдал хэрхэн нөлөөлдөг, тэдэнд сэтгэлзүйн тусламж үйлчилгээний хэрэгцээ шаардлага, хүртээмжийг судалсан судалгааны ажил өнөөг хүртэл хийгдээгүй байна.

Батлан хамгаалах хүчин, энхийг дэмжих үйл ажиллагаанд оролцсон болон оролцож буй цэргүүдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих тусламж үйлчилгээг сайжруулах нь нийгэм-сэтгэлзүйн дарамт, дайн, тулаанаас үүдэлтэй сэтгэлзүйн тулгамдсан асуудал, эмгэгээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой билээ. Иймд бид НҮБ-ийн Энхийг дэмжих ажиллагаанд Монгол улсаас оролцож буй энхийг дэмжигчдийн сэтгэцийн эрүүл мэндэд дайн, тулаантай нутаг орны байдал хэрхэн нөлөөлж буйг судлан тогтоох шаардлагатай байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болно.

Зорилго: Энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдын сэтгэцийн эрүүл мэндийн зарим үзүүлэлтийг сэтгэлзүйн хэв шинжтэй нь уялдуулан судлаж тусламжийн хэрэгцээг судлан тогтооход оршино.


Зорилт:

1. Энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор бэлтгэгдэж буй цэргийн албан хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийн зарим үзүүлэлтийг сэтгэлзүйн хэв шинжтэй нь уялдуулан үнэлэх
2. Энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдын сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн хэрэгцээг судлан тодорхойлох

Арга, аргачлал: Бид энэхүү судалгааг Бүгд Найрамдах Өмнөд Судан улсад явагдах энхийг дэмжих ажиллагаанд бэлтгэгдэж буй цэргийн албан хаагчдын дунд дескриптив судалгааны агшингийн загвараар хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгааны асуумж нь сэтгэцийн эрүүл мэндийг байдлыг тодорхойлоход өргөн ашигладаг олон улсын стандарт сорилуудыг багтаасан. Оролцогч тус бүрийн сайн дурын оролцоог хангах зорилгоор таниулсан зөвшөөрлийн хуудсыг танилцуулан зөвшөөрлийг нь авсан болно. Судалгааны арга аргачлалыг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны хурлаар хэлэлцүүлж, судалгаа явуулах зөвшөөрлийг авсан (2017/З-201401). Нийт 850 цэргийн албан хаагчдад судалгааны асуумжийг тараасан боловч судалгааны шалгуурын дагуу шаардлага хангаагүй судалгааны картыг хасч, шаардлага хангасан 372 оролцогчийн мэдээлэлд статистик боловсруулалт хийн үр дүнг тооцсон болно.

Үр дүн: Судалгаанд 20-47 насны нийт 372 цэргийн албан хаагч таниулсан зөвшөөрлийн хуудастай танилцан, сайн дураар хамрагдсан бөгөөд тэдний 20-34 насныхан 81.1%, байсан бөгөөд хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэйчүүд 90% байв ($p \leq 0.001$). Судалгаанд нийт оролцогчийн 45.1% нь тусгай дунд, 37% нь дээд боловсролтой, 72.3% нь гэр бүлтэй, 72.9% нь 0-3 насны хүүхэдтэй байв ($p \leq 0.001$).

Судалгаанд хамрагдагсадын 99% нь өөрийн хүсэлтээр энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа ба 47.3% ($p \leq 0.001$) нь урьд нь энхийг дэмжих ажиллагаанд оролцож байсан туршлагатай байлаа. Энхийг дэмжих ажиллагааны бэлтгэл нь цэргийн албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэхээс ($p \leq 0.001$) гадна сэтгэлзүйн бэлтгэл ($p \leq 0.001$), стрессийг даван туулах чадвар ($p=0.002$), багаар хамтран ажиллах чадвар ($p \leq 0.001$)-ыг хөгжүүлэх боломжийг олгосон хэмээн 60-78% нь хариулсан байв. Хувь хүний сэтгэлзүйн хэвшинжийг Айзенкийн сорилоор тодорхойлоход, 21.5% холерик, 35.2% сангвиник, 24.2% флегматик, 9.1% нь меланхолик хэв шинжтэй байлаа. Меланхолик хэвшинжтэй оролцогчдын суурь сэтгэл түгшилт ($p=0.004$) болон тухайн үеийн сэтгэл түгшилтийн илрэл ($p=0.019$) бусад хэв шинжийн оролцогчдынхоос статистик ач холбогдол бүхий ялгаатай байв. (Зураг 1.)



Зураг 1. Хувь хүний сэтгэлзүйн хэв шинж ба сэтгэл түгшилтийн илрэлийн түвшинг судалсан дүн.

Холерик хэвшинжтэй оролцогчдын 11% (n=41) нь неврозын урьдал үедээ, 8.3% (n=31) нь неврозын далд илрэл бүхий байсан бол неврозын илэрхий илрэл бүхий 8 оролцогч байв. Сангвиник хэвшинжтэй оролцогчдын 1.08% (n=4) нь неврозын илрэл үгүй, 6.7% (n=25) нь неврозын илрэл бараг үгүй, 23% (n=86) нь неврозын илрэл гарах далд бололцоо бүхий, 4.3% (n=16) нь неврозын урьдал үедээ байгаа нь тодорхойлогдлоо. Харин флегматик хэвшинж бүхий оролцогчдын 3.2% (n=6) нь неврозын илрэл үгүй, 9.4% (n=35) нь неврозын илрэл бараг үгүй, 10.5% (n=39) нь неврозын илрэл гарах далд бололцоо бүхий, 2.7% (n=10) нь неврозын урьдал үедээ байсан бол меланхолик хэв шинжийн оролцогчдоос неврозын илрэл үгүй 1, неврозын илрэл бараг үгүй 1, неврозын илрэл гарах далд бололцоо бүхий 13, неврозын урьдал үедээ байгаа 19 оролцогч тус тус тодорхойлогдсон буюу неврозын илрэл нь меланхолик хэв шинжийн оролцогчдод бусад хэв шинжийн оролцогчдоос статистик ач холбогдол бүхий ($p \leq 0.001$) ялгаатай тодорхойлогдов. (Зураг 2)



Зураг 2. Неврозын илрэлийн түвшин ба хувь хүний сэтгэлзүйн хэв шинжийг судалсан дүн

Архины хэрэглээг үнэлэхэд, нийт оролцогчийн 89.5% (n=333) нь бага хэрэглээтэй, 9.9% (n=37) нь хэтрүүлэн хэрэглэгч байсан бол тус бүр нэг нэг оролцогч хортой үр дагавар өгөхүйц архины хэрэглээтэй, эсвэл архины хамааралтай болох нь тогтоогдсон.

Насны бүлгээр тодруулан судлахад, 20-24 насны бүлэгт архины хэрэглээ багатай 76, хэтрүүлэн хэрэглэгч 2 оролцогч байсан бол нас ахих тусам архины хэрэглээний түвшин ихтэй буюу хэтрүүлэн хэрэглэгч, хортой үр дагавар өгөхүйц хэрэглээтэй оролцогчийн тоо нэмэгдэж, 35-аас дээш насныхны дунд архины хэрэглээ статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. ($p=0.002$)

Хэлцэмж: Цэргийн албан хаагчид нь энхийг дэмжих ажиллагаанд явахын өмнө 3 удаа эрүүл мэндийн үзлэгт орж, зохих сонгон шалгаруулалтанд оролцон тэнцэж 2 сар биеийн болон сэтгэл зүйн бэлтгэл хийсний дараа тухайн нутаг оронд очдог тул эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн хувьд харьцангүй эрүүл хүмүүс байх шаардлагатай байдаг. Судлаач Forbes D (2018) нарын сэтгэцийн эрүүл мэндийн тойм судалгаанд дайн тулааны бүсэд байгаа болон тулалдаанд оролцсон энхийг дэмжигчид нь сэтгэлийн гэмтлийн дараах стрессийн эмгэг, сэтгэл гутрал, мансууруулах бодисын хэтрүүлэн хэрэглээтэй болох зэрэг сэтгэцийн эмгэгт өртөх эрсдэл маш их нэмэгддэг болохыг тогтоосон байна. Түүнчлэн цэргийн албан хаагчдын сэтгэцийн

эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг эрт илрүүлж, шаардлагатай тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх нь чухал болохыг энэхүү тоймд онцолсон байгаа нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байлаа.[6]

Монгол улсын хувьд Афганистан (2009), Ирак (2010) улсуудад энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэлзүйн бэлтгэлийн талаар болон энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчдын сэтгэл санааны байдал, үүрэг гүйцэтгэх хугацаанд тэдний сэтгэл зүйд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлүүдийг судлах зорилготой судалгааг Д.Уламбаяр (2013) хязгаарлагдмал хүрээнд явуулжээ[7]. Тус судалгааны дүнгээс харахад, үүрэг гүйцэтгэж байсан нийт бие бүрэлдэхүүний 20% буюу 35 оролцогчийг хамруулсан ба тэдний 91.6% нь анх удаагаа энхийг дэмжих үйл ажиллагаанд оролцсон байв. Нийт оролцогчийн 23.1% нь "Цагийн байдалд төдийлөн сайн дасан зохицохгүй байна", 15% нь "Харуулын цэг, бусад цэгт үүрэг гүйцэтгэхээс залхдаг, шантардаг тохиолдол их байдаг", 24.3% нь "Ар гэртэй холбоотой асуудал санааг их зовоодог", албан хаагчдын сэтгэлзүйд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийг 52.9% нь "Дарга цэргийн хоорондын харилцааны зөрчил", 20% нь ажлын ачаалал, 10% нь ар гэрийн асуудал хэмээн тодорхойлсон байна.[7,8] Түүнчлэн албан хаагчдын сэтгэлийг зовоодог түгээмэл асуудал нь ар гэрээ санах, эрүүл мэнддээ санаа зовох, үүрэг гүйцэтгэх хугацаанд алдаа дутагдал гаргахаас айдаг, дарамт шахалт (оны ялгаа, албан тушаал, цолны эрэмбээр цэргийн дүрмээс гажууд зүйл хийлгэх) хэмээн хариулсан байжээ. Нийт оролцогчдын 50% нь үүрэг гүйцэтгэх үйл ажиллагаа явагдаж буй газар оронд сэтгэлзүйн тусламж дэмжлэг үзүүлдэг албан тушаалтан байх шаардлагатай, 30% нь "Тухайн цэг дээр үүрэг гүйцэтгэх болон эргүүлийн үүрэг гүйцэтгэх явцад айдаст автах, үүрэг гүйцэтгэхээсээ өмнө түгших тохиолдол гардаг" хэмээн хариулсан байна.[8] Энэ нь бидний судалгааны дүгнэлтэнд дурьдагдсан цэргийн албан хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, стресс тайлах энгийн аргад суралцах дүгнэлттэй нийцэж байгааг харуулж байна.

АНУ, Канад, Их Британи, ОХУ зэрэг хөгжингүй орны сэтгэлзүйч, судлаач нар цэрэг дайны үйл ажиллагаанаас үүдэлтэй нийгэм сэтгэлзүйн хямрал, хариу урвалын түвшинг тогтоон, нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг тусламжийн шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлон үе шаттайгаар хэрэгжүүлснээр цэрэг дайчид, албан хаагч, тэдний ар гэрийнхний бие сэтгэцийн эрүүл мэндийг гамшгаас үүдэлтэй сөрөг үр дагавар, хүндрэлээс урьдчилан сэргийлж амьдралын чанарыг нь дээшлүүлэх боломжтойг тогтоосон байдал нь сэтгэцийн эмгэгт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг авах шаардлагатай бидний судалгааны үр дүнтэй дүйж байна.[9-12]

Дүгнэлт: Энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор бэлтгэгдэж буй цэргийн албан хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийн зарим үзүүлэлт нь хувь хүний сэтгэлзүйн хэвшинжээс хамааран ялгаатай ($p \leq 0.001$) тодорхойлогдож байсан ба архины хэрэглээ 35-аас дээш насныханд илүү байгаа нь цаашид цэргийн албан хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, стресс тайлах энгийн аргад суралцах, сэтгэцийн эмгэгт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг авах шаардлагатайг нотолж байна.

Ном зүй:

1. *Paisley Dodds, 'AP Exclusive: UN child sex ring left victims but no arrests' Associated Press, 12 April 2017*
2. *Hoge,C.W., Castro,C.A., Messer S.C., McGurk,D. Cotting, D.I, Koffman,R.L. Combat duty in Iraq and Afghanistan, mental health problems, and barriers to care.. New England Journal of Medicine, 2004;351:13-22*
3. *Toblin R L., Riviere LA, Thomas JL., et al., Grief and physical health outcomes in U.S. soldiers returning from combat. J.Affect. Disord. 2012 Feb;136(3):469-75. doi: 10.1016/j.jad.2011.10.048. Epub 2011 Dec 9.*
4. *Litz B.T, Schlenger W.E. PTSD in Service Members and New Veterans of the Iraq and Afghanistan Wars: A Bibliography and Critique. PTSD Research Quarter. 2009;20(1):1-8*
5. *Gjerstad Ch.L, Bøe H.J, et.al. Prevalence and Correlates of Mental Health Problems in Norwegian Peacekeepers 18–38 Years Postdeployment. Journal of Traumatic Stress 2020;33:762–772*
6. *Forbes, D., Creamer, M., & Bisson, J. I. The efficacy of interventions aimed at improving mental health and emotional well-being of military personnel. The Lancet Psychiatry, (2018). 5(1), 73-83*
7. *Уламбаяр Д. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ, УБ 2014 х22-23*
8. *Өлзийхутаг Н, Оюунсүрэн Д, Уламбаяр Д, Дэлгэрмаа Н, Амарбаясгалан Ш, Хишигсүрэн З. Энхийг дэмжих үйл ажиллагаанд оролцсон цэрэг дайчид, албан хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлсэн нь. Монголын Анагаахын Оюутны Эрдмийн 4 чуулганы хураангуй, Улаанбаатар, 2015.х 32-33*
9. *Kuehn, B. M. Combat duty in Iraq and Afghanistan, mental health problems, and barriers to care. Journal of the American Medical Association, (2009). 302(12), 1321-1323.*
10. *The Redness Trust. Sexual Exploitation and Abuse in Peacekeeping Operations Improving Victims' Access to Reparation, Support and Assistance.2017;13:3-44*
11. *Jiménez X, Langholtz H.J. Gender Perspectives in United Nations Peacekeeping Operations. Journal of Operations Training. 2018;18-20*
12. *Maguen, S., Madden, E., Cohen, B., Bertenthal, D., Neylan, T., & Seal, K. Association of US Army deployment in Iraq and Afghanistan with risk of mental health disorders. JAMA Psychiatry, 2021; 78(5):547-555*

The relationship between personality types and some mental health indicators of the military personnel who were preparing to the peacekeeping operation

Ulziikhutag N[1], Khishigsuren Z[1]

[1]Department of Mental Health, School of Medicine, MNUMS
E-mail: ulziikhutagmd@gmail.com, Tel: +976- 99043344

Background: Based on the history of the last 30 years of UN peacekeeping operations, it can be seen that combat operations increase the psychological distress of peacekeepers, cause serious mental health problems, and reduce the quality of life of peacekeepers.
Aim: To determine the need for psychosocial care by studying some indicators of mental health of the participants in peacekeeping operations in relationship to their personality types..
Materials and Methods: The study was conducted using a descriptive crossectional design among military personnel preparing for peacekeeping operations in South Sudan.
Results: A total of 372 military personnel aged 20-47 years old, read the informed consent form and voluntarily participated in the study. 81.1% of them were 20-34 years old, and 90% were men ($p \leq 0.001$). 45.1% of all respondents answered that they had special secondary education, 37% had higher education, 72.3% were married, and 72.9% had children aged 0-3 ($p \leq 0.001$). 99% of all the respondents participating in peacekeeping operations by their own request, and 47.3% ($p \leq 0.001$) had experiences of peacekeeping operations in the past. Additionally, 60-78% of all respondents responded that training for peacekeeping operations allowed them to improve their physical development ($p \leq 0.001$), to develop psychological preparation ($p \leq 0.001$), the ability to cope with stress ($p=0.002$), and the ability to work in a team ($p \leq 0.001$). According to the Eysenck Personality Inventory, 21.5% of all respondents were choleric, 35.2% sanguine, 24.2% phlegmatic, and 9.1% melancholic. The manifestation of neurosis was determined to be statistically significant ($p \leq 0.001$) in respondents of melancholic type than in respondents of other types. When assessing alcohol consumption, 89.5% (n=333) of all respondents were low drinkers and 9.9% (n=37) were heavy drinkers, while with increasing age, the number of respondents with high levels of alcohol consumption or heavy drinkers and harmful consumption increased. There was a statistically significant ($p=0.002$) difference in alcohol consumption among over 35 years of age.
Conclusion: Some indicators of mental health of military personnel who are preparing to participate in peacekeeping operations were defined differently ($p \leq 0.001$) depending on the personality types of respondents, and the consumption of alcohol is more in respondents over 35 years of age, which proves the need to take multifaceted measures to protect and support the mental health of military personnel, learn simple ways to relieve stress, and prevent the risk of mental disorders.

Keywords: South Sudan, Anxiety, Alcohol dependence, Military personnels